

**ӨМНӨД-ӨМНӨДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ХӨТӨЛБӨРИЙН /I ШАТНЫ/  
ХҮРЭЭНД БНХАУ-ТАЙ ХАМТРАН МОНГОЛ УЛСЫН “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ”  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ДЭМЖИХ ТЕХНИК ТУСЛАЛЦАА” ТӨСЛИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(2016 оны жилийн эцсийн байдлаар)**

Төслийн нэр, агуулга		Төслийн ажлын гүйцэтгэл				
1	“Өмнөд өмнөдийн хамтын ажиллагаа (ӨӨХА) хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-тай хамтран Монгол Улсын “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг дэмжих техник тусалцаа” GCP/MON/010/CPR төсөл	-Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар, НҮБ-ын ХХААБ хооронд 2009 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан ӨӨХА хэрэгжүүлэх тухай Гурван талт хэлэлцээр. -ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ хооронд 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан GCP/MON/010/CPR төсөл хэрэгжүүлэх тухай хэлэлцээр.				
2	Санхүүжилтийн эх үүсвэр	БНХАУ-ын Засгийн газар				
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих хугацаа	Хүнс, хөдөө аж ахуйн яам <u>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:</u> МУСҮТ, АДОБАЗ Монголын зөгийчдийн нийгэмлэг Монголын тахианы аж ахуй эрхлэгчдийн холбоо Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо Монголын бэлчээрийн менежментийн холбоо “Хилэм Ост” ХХК “Манлай уургач” ХХК				
	Хэрэгжих хугацаа:	2014 оны 11 дүгээр сараас 2016 оны 11 сар				
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	-Монгол улсын “Хүнсний аюулгүй байдал”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх				
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	999,294 ам.доллар			
		Үүнд: 2014-2016 он	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	
	Төслөөс	999,294 ам.доллар	999,294 ам.доллар	100.0		
	ХХААЯ	112,184, 856.0 төг	112,184, 856.0 төг	100.0		
6	Хөтөлбөрийн зорилт:	Биелэлт “Монгол мал” үндэсний хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан “Үр төлийн чанараар шалгарсан гойд ашиг шимт хээлтүүлэгчийн үрийг зохиомол хээлтүүлэгт ашиглах, хөврөл үр шилжүүлэн суулгах зэрэг биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн донор сүрэг бий болгож үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх” үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Малын удмын сангийн үндэсний төв (МУСҮТ), ӨӨХАII төслийн мэргэжилтэнтэй хамтран малын зохиомол хээлтүүлэг, үр гүн хөлдөөх болон үр хөврөл шилжүүлэн суулгах зэрэг мал үржүүлгийн биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн. “Монгол мал” үндэсний хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан “Тэжээлийн нэг ба олон наст ургамал, уургийн агууламж ихтэй шинэ төрлийн таримал тариалах ажлыг өргөтгөх, газар тариалангийн дагавар бүтээгдэхүүнийг малын тэжээлд ашиглах технологийг боловсронгуй болгох” үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн зүгээс Аймаг Дундын Отрын Бүс Ашиглалтын захиргаа (АДОБАЗ), “Монголын бэлчээрийн менежментийн холбоо” (МБМХ), “Манлай уургач” ХХК зэрэг байгууллагуудад тэжээлийн таримлын шинэ сорт сорих, нэг ба олон наст таримал тариалах, эрдэнэшишийн дарш бэлтгэх зэрэг технологи нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн.				
		7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтээр тооцсон ба дунджаар 82.2 хувь, сургалтын төлөвлөгөөний биелэлт 100.0 хувь, худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 90 хувьтай буюу 2016 оны ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ дунджаар 90.7 хувьтай байна.		
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийн хэрэгжилтэд оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагаанд гарсан аливаа зөрчлийг тухай бүр шийдвэрлэж ажилласан.				
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	90.7	Бүрэлдэхүүн хэсгийн биелэлт	Сургалтын төлөвлөгөө	Худалдан авах ажлын төлөвлөгөө
				82.2	100	90
10	Хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			... %	

**ӨМНӨД-ӨМНӨДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ХӨТӨЛБӨРИЙН /II ШАТНЫ/ ХҮРЭЭНД  
БНХАУ-ТАЙ ХАМТРАН МОНГОЛ УЛСЫН “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ”  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ДЭМЖИХ ТЕХНИК ТУСЛАЛЦАА” ТӨСЛИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 03 сарын 09

**Төслийн танилцуулга.** Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар, НҮБ-ын ХХААБ хооронд 2009 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан ӨӨХА хэрэгжүүлэх тухай Гурван талт хэлэлцээр. ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ хооронд 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан GCP/MON/010/CPR төсөл хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн дагуу төсөл хэрэгжиж дууссан байна.

**Төслийн зорилго.** Монгол улсын “Хүнсний аюулгүй байдал”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Төслийн зорилтууд**

**Бүрэлдэхүүн хэсэг 1.** Мал аж ахуй. Мал аж ахуйн фермд мал үржлийн биотехнологи нэвтрүүлж УСҮТ-ийн генийн санг баяжуулах,

**Бүрэлдэхүүн хэсэг 2.** Тэжээл үйлдвэрлэл. Малын тэжээлийн ургамлын үр үржүүлгийн үйлдвэрлэлийг дэмжих, Баруун болон зүүн бүс /300 га туршилтын талбай/-д Хятадын тэжээл тариалах технологийг нэвтрүүлэх,

**Бүрэлдэхүүн хэсэг 3.** Зөгийн аж ахуй. Зүүн бүсийн зөгийн аж ахуй эрхлэгчдэд зөгий үржлийн үйлчилгээг нэвтрүүлэх, зөгийн балны чанарыг шалгах, зөгийн орчны ажиглалтын ур чадвар дээшлүүлэх,

**Бүрэлдэхүүн хэсэг 4.** Хүнсний ногооны үйлдвэрлэл болон цэцэрлэгжүүлэлт. Хүнсний ногооны үйлдвэрлэлд хүлэмжийн болон ил талбайн шинэ технологи нэвтрүүлэх /өвлийн нарлаг хүлэмж, өндөр чанарын үр, боловсруулах технологи гм/,

**Бүрэлдэхүүн хэсэг 5.** Цөөрмийн/Загасны аж ахуй. Загасны өндөг бойжуулагч байгуулах, өндөгний амьдрах хувийг нэмэгдүүлэх,

**Бүрэлдэхүүн хэсэг 6.** Тахианы аж ахуй. Төслийн эхний үе шатанд бий болсон лаборатори, тахианы эрүүл мэндийн үйлчилгээг үргэлжлүүлэх, Өндөглөгч тахианы аж ахуйн тэжээлийн шимт чанарыг сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, тахиа өсгөх байр байгуулах,

**Бүрэлдэхүүн хэсэг 7.** Чадавхи бүрдүүлэх. Сургагч сургах хөтөлбөр /6 аж ахуй/, Талбайн буюу үзүүлэх сургалтын хөтөлбөр, Лаборатори болон байгууламж байгуулах, Гарын авлага хэвлэх, Богино хэмжээний кино бэлтгэх, танилцах аялал,

**Төслийн нийт төсөв.** Үр, Тоног төхөөрөмж 145,573 ам.доллар буюу 306,133,890 сая төгрөг, Сургалт болон танилцах аялалд 90,614 ам доллар буюу 186,224,680 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Төслөөс зарцуулсан нийт хөрөнгө оруулалт 999,294 ам доллар болсон байна.

**Төсөл хэрэгжих хугацаа.** Төслийн ажил 2014 оны 11 дүгээр сараас 2016 оны 11 дүгээр сар хүртэл үргэлжилсэн байна.

**Төслийн санхүүжилт болон удирдлага.** Төслийн ажилд ХХААХҮ-ийн яамнаас 52,521 ам.доллар буюу 112,184,856 сая төгрөгийг зарцуулсан байна. Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнд дараах албаны хүмүүс орж ажилласан байна. Үүнд: *Төслийн Удирдах хорооны дарга:* (1). Л.Чой-ИшСБТГ-ын дарга (2014.10.31 -2015.02.04-ний өдөр хүртэл) (2). ГХХАХ-ийн дарга Т. Эрдэнэжаргал (2015.02.04-2015.08.27-ны өдөр хүртэл); (3) ХХААЯ-ны ТНБДарга Н.Ариунболд (2015.08.27- ); *Үндэсний зохицуулагч:* (1) О.Баярсайхан, ҮХААЯ-ны Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны захирал (2014.10.31 -2015.08.27-ны өдөр хүртэл); (2) ГХХАХ-ийн дарга Б. Биндэръяа (2015.08.27- ); *Хятадын багийн ахлагч, зохицуулагч:* Чанг Хайшан (2014.10.31- ); *НҮБ-ын ХХААБ-ын Төслийн үндэсний менежер:* Г. Гантулга (2014.10.07 – )

**Төслийн ажлын хэрэгжилт.** Төслийн ажлыг 7 үндсэн бүрэлдэхүүн хэсгээр хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна. Үүнд:

**Бүрэлдэхүүн хэсэг 1. Мал аж ахуй. Мал аж ахуйн фермд мал үржлийн биотехнологи нэвтрүүлж УСҮТ-ийн генийн санг баяжуулах**

1.1. МУСҮТ-ийн болон ӨӨХА-ны мэргэжилтэн нар 2 жилийн хугацаанд нийт 258 үнээнд ороо жигдрүүлэлт хийж, 252 саалийн үнээнд зохиомол хээлтүүлэг хийснээс 248 үнээ хээл авч, үр тогтолт 98.4 хувьд хүрсэн нь өнөөгийн зохиомол хээлтүүлэг хийж байгаа түвшнээс даруй 6-7 хувь илүү байна. Мөнтүүнчлэн 8 аймгийн 18 сум, Улаанбаатар, Дархан хотын үхрийн аж ахуй эрхлэгч аж ахуй нэгжүүд 1988 үнээний хээл шалгуулж, аж ахуйн тогтвортой үйл ажиллагааны бэлтгэл

ажил хангахад дэмжлэг үзүүлсэн байна. Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум дахь “Газар Агро” ХХК-д (70 хоног) төслийн зүгээс зөвлөгөө өгч ажилласан бөгөөд 150 үхэрт хээлийн үзлэг хийж, 111 үхэрт ороо идэвхижүүлэгч тарьж, 74 үхэрт зохиомол хээлтүүлэг хийжээ.

1.2. Хэнтий аймгийн Галшир сумын 5малчин өрхийн 600 гаруй ямаанд ороо жигдрүүлэлт хийж, зохиомол хээлтүүлэг хийснээс 594 ямаа хээл авч, үр тогтолт 99 хувьд хүрсэн нь өнөөгийн зохиомол хээлтүүлэг хийж байгаа түвшнээс 19 хувиар илүү байна. Мөн 9478 тун хонины үрийг гарган авч гүн хөлдөөн МУСҮТ-д хонины генийн санд хадгалуулсан байна.

1.3.МУСҮТ-д шаардлагатай байсан хонинд үр хөврөл шилжүүлэн суулгах лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж, эм урвалжийг төслийн санхүүжилтээр захиалан авч, Өвөр Монголын мал аж ахуй судалгааны газар (МААСГ)-ын эрдэмтэдтэй хамтран нийт 30 хонинд үр хөврөл шилжүүлэн суулгах 1 сар үргэлжилсэн практик сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд хонинд үр хөврөл суулгах биотехнологийн дэвшилтэт аргыг анх удаа малын үржлийн мэргэжилтэн болон мэргэжлийн ангийн оюутан нар сурч, цаашид хонинд хөврөл шилжүүлэн суулгах ажлын эхлэлийг тавьсан байна. Мөн МУСҮТ, МААСГ-ын хооронд зохиомол хээлтүүлэг хийх, үр хөврөл шилжүүлэн суулгах биотехнологийн дэвшилтэт аргыг Монгол улсад хөгжүүлэх тал дээр мэргэжилтэн сургах, хамтран ажиллах урт хугацааны санамж бичигт 2016 оны 9 сарын 13-нд хоёр тал гарын үсэг зурсан байна.

1.4.НҮБ-ын ХХААБ-ын тендерийн журмаар 331717 ам.доллар буюу 6499994 төгрөгөөр FT-250 трактор анжисын хамт, 9GL-1,8 хадлангийн иж бүрдэл тус бүр нэгийг худалдан авч МУСҮТ-д нийлүүлжээ.

## **Бүрэлдэхүүн хэсэг 2. Тэжээл үйлдвэрлэл. Малын тэжээлийн ургамлын үр үржүүлгийн үйлдвэрлэлийг дэмжих, Баруун болон зүүн бүс /300 га туршилтын талбай/-д Хятадын тэжээл тариалах технологийг нэвтрүүлэх**

Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

2.1.МБМХ нь Төв аймгийн Баянхангай сум дахь үйлдвэрлэлийн талбайдаусалгаагүй нөхцөлд тэжээлийн ургамал тариалах технологи нэвтрүүлэх ажлыг хийж, ногоон масс хураан авах зорилготойгоор 8 га талбайд судан өвс, 200 га талбай дарвай, овъёосны холимог тариалж нийт 130.5 тонн ногоон масс хурааж га-аас 62.7 цн ургац хураан авсан үр дүнтэй байна.

2.2.“Бумбат таван богд” хоршоо нь Сэлэнгэ аймгийн Жавхлант сум дахь талбайдаа ӨӨХА-ны төслийн зөвлөмж, (тарилтын өмнөх хөрс боловсруулалт, тариалах хугацаа, хог ургамалтай тэмцэх арга хэмжээ, усалгаа) тариалах технологийг мөрдөж, даршны зориулалтаар 2015 онд эрдэнэшишийн “Же Дан” сортыг 13 га талбайд, 2016 онд “Нан Бей И Хао” сортыг 13 га талбайд тариалж, 2015 онд 35 тонн буюу га - аас 2.3 тонн ногоон масс, дараагийн жилд 100 тонн буюу га-аас 7.7 тонн ногоон масс хурааж, ургацын хэмжээг 3.3 дахин нэмэгдүүлсэн үр дүнтэй байна. Улмаар бүх хураан авсан ногоон массаар дарш бэлтгэж эрчимжсэн саалийн үнээний фермд нийлүүлж, хоршоо ашиг орлогоо нэмэгдүүлжээ.

2.3.“Манлай уургач” ХХК нь Төв аймгийн Эрдэнэ сум дахь үйлдвэрлэлийн талбайдаа БНХАУ-ын даршны эрдэнэшишийн “Ней Дан-205”, “Же Дан-37”, “Донг Линг Бай”, “Нан Бей И Хао”, “Фен Зао 303” зэрэг 5 сорт, БНХАУ-ын гаралтай хүнсний эрдэнэшишийн “Жинг Кэ Нуо 2000”, “Цай Нуо И Хао”, “Шэнг Ши Жин Нуо”, “Ө Гүй”, “Хай Лин”, “Бо Ген” зэрэг 6 сортыг Монгол орны нөхцөлд тариалж нутагших боломжтой эсэхийг туршиж үзсэн байна. Үүнээс даршны эрдэнэшишийн “Нан Бей И Хао”, хүнсний эрдэнэшишийн “Бо Ген” сортууд ирээдүйтэй болохыг урьдчилан тогтоосон байна. Тус компани ӨӨХА-ны төслийн мэргэжилтний зааварчилгааны дагуу “Царгасны Бургалтай” сортыг 5 га-д (эхний жилдээ соёлолт жигд, 15-20 см өндөр ургасан), “Судан өвсний эрлийз” сортыг 5 га-д тус тус тариалж, тариалах технологио сайжруулсан.

2.4.МБМ-ийн Холбоо, “Манлай уургач” ХХК, АДОБА-ын Захиргаа нь сорт сорих, тэжээлийн таримлын тариалах технологийг нэвтрүүлэх, сайжруулах ажлын хүрээнд нэг болон олон наст тэжээлийн таримлын үр (царгас, судан өвс, эрдэнэшиш, арвай, овъёос, ерхөг), хөдөө аж ахуйн трактор, дагалдах тоног төхөөрөмжийг (ази культватор, роторт культватор, үрсэлгээ суулгагч, тармуур, хадуур, GPS) захиалан ӨӨХА төслийн санхүүжилтээр ХХААХҮЯ-ны Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас худалдан авч үйл ажиллагаандаа ашигласан байна.

2.5.“Манлай Уургач” ХХК-д НҮБ-ын ХХААБ-ын тендерийн журмаар 6293.37 ам.доллар буюу 12,255,680 төгрөгөөр Ази культватор АМС-900, Роторт культватор WR 1250 SG-1, Хүнсний ногооны үрсэлгээ суулгагч тус бүр нэгийг худалдан авч нийлүүлсэн. Монголын бэлчээрийн менежментийн холбоо худалдан авах тоног төхөөрөмжийн нэр төрөлд өөрчлөлт хийж, НҮБ-ын ХХААБ-ын зөвшөөрсний дагуу тендерийн журмаар 12,000 ам.доллар буюу 23,940,000 төгрөгөөр KPF-4M хадуур болон SITREX RP /8V/ тармуурыг “Агротрак” ХХК-аас худалдан авч нийлүүлсэн.

**Бүрэлдэхүүн хэсэг 3. Зөгийн аж ахуй.** Зүүн бүсийн зөгийн аж ахуй эрхлэгчдэд зөгий үржлийн үйлчилгээг нэвтрүүлэх, зөгийн балны чанарыг шалгах, зөгийн орчны ажиглалтын үр чадвар дээшлүүлэх

3.1. “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрт тусгасан “Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах” зорилтын дагуу ӨӨХА II төслийн хүрээнд Монголын зөгийчдийн нийгэмлэг хатан зөгий үржүүлэг, зөгийн бүлийн маллагааны технологийг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүллээ.

3.2. Монголын зөгийчдийн нийгэмлэгийн Дорнод аймгийн Халх гол сум дахь зөгийн сууринд 2 жилийн хугацаанд ӨӨХА-ны зөгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж, нэг бүлээс авдаг балны гарцыг 20 кг-аас 30 кг хүртэл өсгөж, бүтээмжийг 50 хувиар нэмэгдүүлсэн. Мөн нийт 200 ширхэг хатан зөгий үржүүлж (нийгэмлэгийн гишүүн аж ахуй нэгждээ тараасан), 35 бүл зөгийг 130 бүл болтол өсгөж, бүлийн тоогоо 4.5 дахин нэмэгдүүлсэн байна. Зөгийнөөс сүүнцэр, лав хураан авах арга технологийг заалгаж 1000 гр сүүнцэр, 50 кг лав хураан авч зөгийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэх ажлын эхлэлийг тавьсан тухай дүгнэлт гаргасан.

3.3. Монголын зөгийчдийн нийгэмлэг гишүүн аж ахуй нэгж байгууллагын хэрэгцээ шаардлагад үндэслэн 15 ширхэг зөгийн бал ялгуур, 500 хайрцаг сэмж, 1000 ш тусгаарлах торыг нийт 41 аж ахуй нэгжийн бизнес үйл ажиллагааг дэмжих зорилгоор ӨӨХА төслийн санхүүжилтээр худалдан авч нийлүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Тус нийгэмлэг ӨӨХА төслийн мэргэжилтнээр дамжуулан БНХАУ-аас зөгийн мэргэжилтэнг 5 сарын хугацаатай урьж ажиллуулан Сэлэнгэ, Булган, Төв аймгийн зөгийн аж ахуй эрхлэгчдэд мэргэжлийн услалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн түүнчлэн төслийн зүгээс Зөгийн аж ахуйгаа өргөтгөх, бизнесээ өргөжүүлэх аж ахуй нэгжүүдийг хөрөнгө оруулах сонирхолтой БНХАУ-ын энэ салбарын иргэдтэй холбоо тогтоож хамтран ажиллах гэрээ хэлэлцээр хийхээр харилцан тохиролцсон байна.

**Бүрэлдэхүүн хэсэг 4. Хүнсний ногооны үйлдвэрлэл болон цэцэрлэгжүүлэлт.** Хүнсний ногооны үйлдвэрлэлд хүлэмжийн болон ил талбайн шинэ технологи нэвтрүүлэх /өвлийн нарлаг хүлэмж, өндөр чанарын үр, боловсруулах технологи гм/

4.1. “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрт тусгасан “Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах” зорилтын дагуу ӨӨХА II төслийн хүрээнд ашиг шим хүртэгч Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо (ХААЭХ) нь хүнсний ногооны шинэ сорт сорих, хүлэмжинд хүнсний ногоо ургуулах агротехнологийг сайжруулж, нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүллээ.

4.2. “Түмэн сүйх” ХХК, “Сэнжит оюу” ХХК нь үйлдвэрлэлийн талбайдаа өргөст хэмхийн “Голланд-971” (БНХАУ-д нутагшуулсан), улаан лоолийн “Тайван дагина”, “5 өнгөт”, усан үзмийн “Жин ян”, гүзээлзгэний “Хун-ян” зэрэг сортуудыг Монгол орны нөхцөлд тариалж нутагших боломжтойг туршиж үзсэн байна. Үүнээс “Голланд-971” (БНХАУ-д нутагшуулсан) сорт нь ирээдүйтэй, манай орны худалдаанд тохирсон гадаргуу, өнгө, хэлбэртэй болох нь тогтоогдож улмаар 2016 онд “Сэнжит оюу” ХХК үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. Тус компани нь ӨӨХА-ны мэргэжилтний зааварчилгааны дагуу өргөст хэмх тариалах агротехнологийг баримтлан ажиллаж, нийт 2000 м<sup>2</sup> шилэн хүлэмжнээс 2014 онд 7,000 кг, 2015 онд 8530 кг ургац тус тус хурааж авч ургацыг 21 хувиар нэмэгдүүлсэн ба 2016 онд 13,247 кг өргөст хэмх хурааж 2015 онтой харьцуулахад 55 хувиар ургацаа нэмэгдүүлжээ.

4.3. “Түмэн сүйх” ХХК нь ӨӨХА-ны мэргэжилтний зөвлөмжийн дагуу 100 м<sup>2</sup> талбайд хөрсийг тусгайлан боловсруулж (хар шороо, бууц, галлагаанаас гарсан нүүрсний үнсийг шигшиж, тэнцүү хэмжээгээр хольж, өргөн хамар хийж), туршилтаар тарьсан улаан лоолийн ургац уламжлалт аргаараа тарьсан ургацаас 2-3 кг/м<sup>2</sup> -аар өссөн дүн үзүүлсэн байна.

4.4. “Түмэн сүйх” ХХК, “Сэнжит оюу” ХХК нь хүлэмжийн таримлын шинэ сорт сорих, тариалах агротехнологийг нэвтрүүлэх, сайжруулах ажлын хүрээнд өргөст хэмхийн үр, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж (Хятад, Солонгос, Итали улсад үйлдвэрлэгдсэн трактор+анжис+хөрс тэгшлэх, бутлагч+байцаа суулгах машин, 2 га талбайн намираа усалгааны систем, хэмх, лооль арчлах өргөгч төхөөрөмж)-ийг ӨӨХА төслийн санхүүжилтээр ХХААХҮЯ-ны Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас худалдан авч үйл ажиллагаандаа ашигласан байна.

4.5. “Сэнжит Оюу” ХХК-д НҮБ-ын ХХААБ-ын тендерийн журмаар 7513,65 ам.доллар буюу 9723000 төгрөгөөр FT-250 трактор анжисын хамт, цацруулагч усалгааны систем тус бүр нэгийг худалдан авч нийлүүлсэн. “Түмэн сүйх” ХХК-д НҮБ-ын ХХААБ-ын тендерийн журмаар 5852,52 ам.доллар буюу 11590909 төгрөгөөр В-AIR 1400 хүлэмжийн ногоо арчлагч төхөөрөмжийг худалдан авч нийлүүлсэн байна.

4.6. ХААЭ-ийн Холбоо ӨӨХА төслөөр богино хугацааны зөвлөхийг 1 сарын хугацаатай

урьж ажиллуулж, холбооны гишүүн аж ахуй нэгжүүдэд хүлэмжийн таримлын агротехникийн чиглэлээр зөвлөгөө өгүүлсэн ба мөн Хятад загварын нарлаг хүлэмжийн стандартыг Монгол орны нөхцөлд тохируулан хамтран боловсруулсан байна.

**Бүрэлдэхүүн хэсэг 5. Цөөрмийн/Загасны аж ахуй.** Загасны өндөг бойжуулагч байгуулах, өндөгний амьдрах хувийг нэмэгдүүлэх

5.1.“Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрт тусгасан “Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах” зорилтын дагуу ӨӨХА II төслийн хүрээнд ашиг шим хүртэгч ХААИС-ийн Мал аж ахуй биотехнологийн сургууль (МААБС) нь цөөрмийн загасны аж ахуйг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна.“Хилэм загасны өвчин эмгэг” номыг хамтран боловсруулж олны хүртээл болгосон байна.

5.2.МААБ-ийн Сургууль нь ӨӨХА-ны урт болон богино хугацааны мэргэжилтнүүдтэй хамтран төрөл бүрийн загас үржүүлэг, арчилгаа маллагаа, өвчин эмгэгийн талаар оюутан сурагчдад онолын болон практик сургалт хийж тодорхой мэдлэг эзэмшүүлсэн.“Хилэм загасны зарим өвчин, урьдчилан сэргийлэх аргууд” гарын авлагыг хамтран боловсруулсан нь олны хүртээл болоод байна. Сургууль дэргэдээ цөөрмийн загас үржүүлгийн лаборатори байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд мэргэжилтэн нараас зөвлөгөө авч, цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллахаар төлөвлөж байна. Цөөрмийн загасны аж ахуй эрхлэх технологи, практик ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийгдсэн байна.

5.3.“Хилэм-Ост” ХХК-д НҮБ-ын ХХААБ-ын тендерийн журмаар 4480 ам.доллар буюу 8776784 төгрөгөөр хар замаск (25 кг, 76 уут), пасатны тор 10 ш, булан тор 32 ш, ус нэвтрүүлдэггүй будаг 80 ш (18кг), усан суурьтай будаг 15 ш (загас үржүүлгийн цөөрмийн усан сан байгуулахад шаардагдах материал) зэргийг худалдан авч нийлүүлсэн. Өвлийн улиралд хилэм загасыг үржүүлэх цөөрмийн зураг төслийг боловсруулж “Хилэм-Ост” ХХК-д хүлээлгэн өгсөн

**Бүрэлдэхүүн хэсэг 6. Тахианы аж ахуй.** Төслийн эхний үе шатанд бий болсон лаборатори, тахианы эрүүл мэндийн үйлчилгээг үргэлжлүүлэх, Өндөглөгч тахианы аж ахуйн тэжээлийн шимт чанарыг сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, тахиа өсгөх байр байгуулах

6.1.“Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрт тусгасан “Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах” зорилтод дэмжлэг үзүүлэх зорилгоор ӨӨХА II төслийн хүрээнд “Ти-Эс-Эй-Ти” ХХК-тай хамтран тахианы тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, халдварт өвчин оношлох, хянах, дэгдээхэй болон бие гүйцсэн тахианы арчилгаа маллагааны технологи нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна.

6.2.Төслийн ажлын хүрээнд Тахианы аж ахуйн өдөр тутмын маллагааны технологи, тахианы халдварт өвчин, тархалтын шалтгаан, эмчилгээ болон тахианы тэжээлийн түүхий эд, найрлага, тэжээл үйлдвэрлэх боломж зэрэг суурь судалгаа хийгдсэн байна.

6.3.“Ти-Эс-Эй-Ти” ХХК-нь тахиаг тэжээх аргачлал, байрны гэрэлтүүлгийн хангамж, агааржуулалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн горимын зааварчилгаа авч, дэгдээхэй болон бие гүйцсэн тахианы арчилгаа маллагааны технологио сайжруулсан байна. Тус компани нь БНХАУ-с 10000 дэгдээхэй худалдан авч, тэдгээрийг ямар нэгэн өвчин эмгэгээс ангид байлгаж, амьдралтыг 99.7 хувьд барьж, бие гүйцсэн шатанд нь хүргэж үйлдвэр- лэлийнхээ бүтээмжийг нэмэгдүүлсэн байна. 6.4.Мал эмнэлэг, хорио цээрийн үйлчилгээний горимыг зохицуулах ажлын хүрээнд өдөр тутмын урьдчилан сэргийлэх, хорио цээр тогтоох арга ажиллагаанд зөвлөгөө авч, тахианы 20 гаруй өвчнийг оношлох, хянах аргачлалыг сурсан байна. Мөн нэгж бүтээгдэхүүний өөрийн өртгийг нэмэгдүүлж буй тахианы тэжээлийн өөрийн өртгийг бууруулах тал дээр экспертээс зөвлөгөө авч цагт 2-3 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тоног төхөөрөмжийг төслийн санхүүжилтээр БНХАУ-аас худалдан авсан байна.

6.5.Монгол орны нөхцөлд (тэжээл үйлдвэрлэх түүхий эдийн судалгаа хийж) тохирсон тахианы тэжээлийн орц нормыг боловсруулж, тэжээлийн түүхий эдийг 100 хувь гаднаас импортлохыг зогсоож, зөвхөн 30 хувийг нь гаднаас, бусдыг нь дотоодын түүхий эдээр орлуулж, тэжээлд зарцуулах зардлаа 10 хүртэл хувь бууруулах ашигт ажиллагааны тооцоо хийгдсэн байна. Монголд тахианы аж ахуй эрхлэх технологийг сайжруулах зорилгоор “Өндөглөгч тахиа” гарын авлагыг тахианы аж ахуй эрхлэгчдэд зориулан боловсруулсан нь олны хүртээл болоод байна

**Бүрэлдэхүүн хэсэг 7. Чадавхи бүрдүүлэх.** Сургагч сургах хөтөлбөр /6 аж ахуй/, Талбайн буюу үзүүлэх сургалтын хөтөлбөр, Лаборатори болон байгууламж байгуулах, Гарын авлага хэвлэх, Богино хэмжээний кино бэлтгэх, танилцах аялал

**7.1 Хөдөө аж ахуй эрхлэгчдийн практик хэрэглээний дадал бэхжиж, мэдлэг дээшилнэ**

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхийг мал үржүүлэг чиглэлээр бэхжүүлсэн байдал. Үхрийн хээл шалгалт, ороо жигдрүүлэлт, зохиомол хээлтүүлэг чиглэлээр мал үржүүлэгч техникчдийн чадварыг сайжруулах зорилготой 4 удаагийн сургалт, зөвлөх, сургах үйл ажиллагааг ХХААХҮЯ, ӨӨХА төслийн санхүүжилтээр зохион байгуулж МУСҮТ-ийн хөдөө орон нутгийн салбарт ажил-ладаг 99 мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мал үржүүлэг чиглэлээр 5 аймгийн 43 аж ахуй нэгжид зөвлөгөө өгч, МУСҮТ-ийн 4 мэргэжилтэнд бод, бог малын хээлтүүлэг чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

**7.2 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхийг малын тэжээл үйлдвэрлэл чиглэлээр бэхжүүлсэн байдал**

АДОБАЗ болон МБМХ-ны захиалгаар тэжээлийн өндөр агууламжтай таримлыг тариалах технологийг сайжруулах чиглэлээр Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн тэжээлийн таримал тариалагч аж ахуй нэгж байгууллага, орон нутгийн 140 мэргэжилтнийг хамруулсан 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Малын тэжээлийн үйлдвэрлэл чиглэлээр “Борнуур эко хүнс” ХХК, “Хосдалбаа” ХХК, “Елекав” ХХК, “Газар агро” ХХК зэрэг 4 аж ахуй нэгжид мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.

**7.3 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхийг зөгийн аж ахуй чиглэлээр бэхжүүлсэн байдал**

Монголын зөгийчдийн нийгэмлэг зөгийн хавар, зуны маллагааны менежмент, өвөлжилт, эмчилгээ, хатан зөгий үржүүлэг, зохиомол хээлтүүлэг зэрэгсэдвээр ӨӨХА-ны төсөлтэй хамтран төслийн болон нийгэмлэгийн санхүүжилтээр 8 удаагийн сургалт зохион байгуулж 290 хүнийг сургалтад хамруулж, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна. Мөнтүүнчлэн Зөгийн аж ахуй чиглэлээр “Монголын зөгийчдийн нийгэмлэг”-ийн гишүүн аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.

**7.4 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхийг хүнсний ногооны үйлдвэрлэл чиглэлээр бэхжүүлсэн байдал**

ХААЭХ болон ӨӨХА төслийн санхүүжилтээр хүлэмжинд төрөл бүрийн хүнсний ногоо тариалах технологи, Хятад загварын “Наран хүлэмж” барих аргачлал, хүлэмжийн таримлын ургамал хамгаалал, хорио цээрийн чиглэлүүдээр Дархан, Сэлэнгэ, Улаанбаатар хотын хүлэмжийн аж ахуй эрхлэгч 240 иргэдийг хамруулж, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан байна. Хүнсний ногооны үйлдвэрлэл чиглэлээр “Мөнх ногоон тал” ХХК, “Атрын шим” ХХК, “Оюу талс” ХХК, “Хар бухын гол” ХХК, “Асрал” ХХК, “Грийн сити гарден” ХХК, “Гранд ложистик” ХХК, “Баатрууд тэнгэр” ХХК, “Грийн арт” ХХК, “Хаан жимс-ЭсБиТи” ХХК, “Өгөөж хайрхан” ХХК, “Хонгор түрүү” хоршоо, “Тайванбадрах” ББНөхөрлөл, “Ижил дөрвөн сарнай” хоршоо, “Органик монгол” хоршоо зэрэг нийт 17 аж ахуй нэгж, байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.

**7.5 Тахианы аж ахуйн чиглэлээр бэхжүүлсэн байдал**

Өдөр тутмын урьдчилан сэргийлэх, хорио цээр тогтоох арга ажиллагаанд зөвлөгөө өгч ажилласан. Тахианы 20 гаруй өвчнийг хэрхэн хянах, тэжээлийн сонголт, эмийн хэрэглээ, тахианы хорогдлыг багасгах буюу огт хорогдолгүй болгох тал дээр иж бүрэн зөвлөгөө өгч ажилласан. Эксперт Ву Дуо шинэ тоног төхөөрөмж суурилуулах ажилд зөвлөгөө өгч ажилласан. ӨӨХА-ны тахианы мэргэжилтэн Ву Дуо “Ти-Эй-Эс-Ти” ХХК-д тахиаг тэжээх ухаан, өвчин оношлох болон эмчлэх аргыг олон удаагийн давтамжтайгаар сургасан ба тахианы аж ахуйн үйлдвэрлэл чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажиллажээ.

**7.6 Цөөрмийн аж ахуйн чиглэлээр бэхжүүлсэн байдал**

ӨӨХА-ны загасны мэргэжилтэн Зао Зиёнг нь ХААИС-ийн Мал Аж Ахуй Биотехнологийн сургуулийн 20 оюутанд “Загас тэжээх арга”, “Загасны өвчин судлал” сэдвээр 2 удаагийн практик ач холбогдол бүхий хичээл заасан. Сэлэнгэ аймагт 2015 оны 5 сард 14 хоногийн хугацаатай ХААИС-ийн Мал Аж Ахуй Биотехнологийн сургуулийн загасны аж ахуйн ангийн 14 оюутанд загас үржүүлгийн практик дадлагын сургалт хийж тэдэнд загасны төрөл зүйл, өсөлт, хөгжилт, өвчний талаар нарийвчилсан сургалт явуулсан байна. “Хилэм-Ост” ХХК компанийн загас үржүүлгийн өдөр тутмын технологийн арга ажиллагааг сайжруулах (тэжээл, хорио цээр, эмчилгээ) талаар зөвлөгөө өгсөн. Цөөрмийн загасны аж ахуй чиглэлээр “Хилэм-Ост” ХХК, “Жижиг горхи” ХХК зэрэг аж ахуй нэгжүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.

**7.7 Талбайн болон үзүүлэх сургалтын талаар**

Төслийн хүрээнд Өвөр Монголын мал аж ахуй судалгааны газар (МААСГ)-ын эрдэмтэдтэй хамтран нийт 30 хонинд үр хөврөл шилжүүлэн суулгах 1 сарын хугацаатай практик

сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар хонинд үр хөврөл суулгах биотехнологийн дэвшилтэт аргыг анх удаа малын үржлийн мэргэжилтэн болон мэргэжлийн ангийн оюутан нар сурч, цаашид хонинд хөврөл шилжүүлэн суулгах ажлын эхлэлийг тавьсан байна.

Мал үржүүлгийн дэвшилтэт биотехнологийн аргыг практикт нэвтрүүлэх ажлын хүрээнд 3 ямаанаас хөврөл үр угаан авч 38 ямаанд хөврөл шууд шилжүүлэн суулгаж, МУСҮТ-ийн 6 ажилтанд зааж сургах ажлыг зохион байгуулсан.

Зөгий үржүүлгийн технологийг практикт нэвтрүүлэх ажлын хүрээнд 80 ширхэг хатан зөгий үржүүлж, түүнийг үржүүлэх арга ажиллагааг зөгийчдийн нийгэмлэгийн гишүүн аж ахуй эрхлэгчдэд зааж сургаж. Зөгий маллагааны практик ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд нийт 459 бүл зөгийнд арчилгаа хийж, зөгийчдөд зааварчилгаа өгч техник туслалцаа үзүүлсэн. 300 бүл зөгийнөөс 10 кг лав хураан авч, мөн сүүнцэр гаргаж авах аргыг зааж, 1000 гр сүүнцэр үйлдвэрлэсэн байна.

Төслийн мэргэжилтэн Зиёнг ХААИС-ын Мал Аж Ахуй Биотехнологийн сургуулийн 20 оюутанд “Загас тэжээх арга”, “Загасны өвчин судлал” сэдвээр 2 удаа практик хичээл заасан байна. ХААИС-ийн Мал Аж Ахуй Биотехно-гийн сургуулийн загасны аж ахуйн ангийн 14 оюутан Сэлэнгэ аймагт 2015 оны 5 сард 14 хоногийн хугацаатай загас үржүүлгийн практик дадлагын сургалт хийж тэдэнд загасны төрөл зүйл, өсөлт, хөгжилт, өвчний талаар нарийвчлан зааж сургасан байна.

### 7.8 Гарын авлага

“Зөгийний аж ахуй эрхлэх технологи” гарын авлагыг боловсруулсан. “Өндөглөгч тахиаг үржүүлэх менежмент” сэдэвт гарын авлагыг Монгол орны нөхцөлд тохируулан зөвлөмж хэлбэрээр боловсруулсан. “Загасны өвчинтэй тэмцэх арга ажиллагаа” сэдэвт гарын авлагыг боловсруулсан.

### 7.9 Танилцах аялал

НҮБ-ын ХХААБ, БНХАУ-ын ХААЯ-ны Гадаад Харилцаа Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны хэлтэс хооронд байгуулсан гэрээний дагуу БНХАУ-д хийх танилцах аялалыг Бээжин, Шанхай, Хөх хот, Хайлар, Нанчангд 2015 оны 9 сар, 2016 оны 9 сард тус тус амжилттай зохион байгуулсан. Тус хоёр танилцах аялалд ХХААХҮЯ-ны ТНБ-ийн дарга Н.Ариунболд, мөн яамны Гадаад харилцаа хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Биндэрьяа, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөл бүхий нийт 22 хүн оролцсон байна.

Эхний удаагийн танилцах аялалын үеэр буюу 2015 оны 9 сарын 21-ны өдөр ХХААХҮЯ-ны ТНБ-ийн дарга Н.Ариунболд БНХАУ-ын ХААЯ-ны дэд сайд (ерөнхий агрономич) Сун Зонгхуатай хоёр орны дээд хэмжээний уулзалтыг Бээжин хотноо хийсэн бөгөөд хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа болон ӨӨХА-ны төслийн хэрэгжилтийн талаар тодорхой саналуудыг солилцсон байна.

**Төслийн үр дүнг хэвлэл мэдээлэл болон олон нийтэд сурталчлах.** MNT телевизийн “Зочинтой Ярилцах Цаг” нэвтрүүлэгт ӨӨХА төслийн талаар 20 минутын танилцуулгыг хийж, олон нийтэд 5 удаа давтан хүргэсэн.

БНХАУ-ын Шинхуа Агентлагаас ӨӨХА-ны талаарх тусгай сурвалжлага хийж, төсөлд оролцож байсан 20 хүнээс ярилцлага авч нэвтрүүлэг бэлтгэсэн.

Сэлэнгэ аймгийн Мандалд зохион байгуулсан 2 өдрийн “Хүлэмж болон ил талбайд хүнсний ногоо тариалах технологи” сэдэвт сургалтын явцыг орон нутгийн телевизээр иргэдэд хүргэж, төслийн үйл ажиллагааг сурталчилсан. Төслийн багийн ахлагч Чанг Хайшан Монголын өдөр тутмын “Өнөөдөр” сонинд нэг удаа ӨӨХА-ны төслийн зорилго, чиглэл, үйл ажиллагаа гарсан үр дүнгийн талаар ярилцлага өгсөн байна.

Төслийн менежер Г.Гантулга “Малчин” сэтгүүлд 2015 онд хэрэгжүүлсэн төслийн үр дүнг бичиж олон нийтэд сурталчилсан. Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, тоног төхөөрөмж хүлээлгэж өгөх арга хэмжээ зэргийг тухай бүрт нь сурталчилж, олон нийтэд мэдээлж ажилласан байна.

### Хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ

д/д	Хөтөлбөрийн зорилт	Үнэлгээ
1	Бүрэлдэхүүн хэсэг 1. Мал аж ахуй. Мал аж ахуйн фермд мал үржлийн биотехнологи нэвтрүүлж УСҮТ-ийн генийн санг баяжуулах	100
2	Бүрэлдэхүүн хэсэг 2. Тэжээл үйлдвэрлэл. Малыг тэжээлийн ургамлын үр үржүүлгийн үйлдвэрлэлийг дэмжих, Баруун болон зүүн бүс /300 га туршилтын талбай/-д Хятадын тэжээл тариалах технологийг нэвтрүүлэх	70
3	Бүрэлдэхүүн хэсэг 3. Зөгийн аж ахуй. Зүүн бүсийн зөгийний аж ахуй эрхлэгчдэд зөгий үржлийн үйлчилгээг нэвтрүүлэх, зөгийн балны чанарыг шалгах, зөгийний орчны ажиглалтын ур чадвар дээшлүүлэх	70

4	Бүрэлдэхүүн хэсэг 4. Хүнсний ногооны үйлдвэрлэл болон цэцэрлэгжүүлэлт. Хүнсний ногооны үйлдвэрлэлд хүлэмжийн болон ил талбайн шинэ технологи нэвтрүүлэхөвлийн нарлаг хүлэмж, өндөр чанарын үр, боловсруулах технологи гм	70
5	Бүрэлдэхүүн хэсэг 5. Цөөрмийн/Загасны аж ахуй. Загасны өндөг бойжуулагч байгуулах, өндөгний амьдрах хувийг нэмэгдүүлэх	90
6	Бүрэлдэхүүн хэсэг 6. Тахианы аж ахуй. Төслийн эхний үе шатанд бий болсон лаборатори, тахианы эрүүл мэндийн үйлчилгээг үргэлжлүүлэх, Өндөглөгч тахианы аж ахуйн тэжээлийн шимт чанарыг сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, тахиа өсгөх байр байгуулах	90
7	Бүрэлдэхүүн хэсэг 7. Чадавхи бүрдүүлэх. Сургагч сургах хөтөлбөр /6 аж ахуй/, Талбайн буюу үзүүлэх сургалтын хөтөлбөр, Лаборатори болон байгууламж байгуулах, Гарын авлага хэвлэх, Богино хэмжээний кино бэлтгэх, танилцах аялал	
Дундаж		82.8

### ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах тал	Хэрэгжилт	Үнэлгээ, хувь
1	Төслийн нэгж байгуулах	Төслийн нээлт	ХХААЯ, НҮБ-ын ХХААБ	-2014 оны 11 сарын 01-нд төслийн нэгж байрлах оффисыг тохижуулж, шаардлагатай тавилга, компьютер, хэвлэгч зэрэг техник хэрэгслээр хангасан. 2015 оны 11 сард хятад хэлний орчуулагч- нарийн бичиг авч ажиллуулсан ба 2015 оны жилийн эцсийн байдлаар төслийн нэгжийн ажиллагаа тогтмол болсон.	100.0
2	Эхлэлтийн семинар/төсөл нээх	Төслийн нээлт	ХХААЯ, НҮБ-ын ХХААБ	-Төслийн албан ёсны нээлт, танилцуулах семинарыг 2015 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, төслийн үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга замын талаар танилцуулга хийж 2015 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө-ний төслийг хэлэлцсэн байна. Нээлтийн үйл ажиллагааг олон нийтийн томоохон телевиз, сонины сэтгүүлчид сурвалжилж, ярилцлага авч, нийтэд сурталчилсан байна.	100.0
3	Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах /тал бүр/	Үйл ажиллагаа эхэлснээс 1 сарын дараа	ХХААЯ, Төслийн нэгж	-Төслийн 2015 оны үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөний төслийг худалдан авах тоног төхөөрөмж, бараа материалын жагсаалтын хамт боловсруулан Удирдах хорооны гишүүдийн саналыг тусган Удирдах хорооны даргаар 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдөр батлуулсан байна.	100.0
4	Хагас жил тутмын уулзалт	Үйл ажиллагаа эхэлснээс 6 сарын дараа	ХХААЯ, НҮБ-ын ХХААБ Төслийн нэгж	-Төслийн 6 сар тутмын анхны уулзалтыг 2015 оны 05 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уулзалтанд НҮБ-ын ХХААБ-ын шадар суурин төлөөлөгч Перси Мисика, ХАААЯ-ны СБТГ-ын дарга Л.Чой-Иш, ӨӨХА-ны шинжээч, мэргэжилтэн нар, Монгол талын хамтрагч төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн	100.0



				<p>төлөөлөл оролцсон.</p> <p>-Уулзалтын зорилго нь төслийн явц, хэрэгжилт, менежментийг дүгнэх, зөвлөмж өгөхөд оршиж байв. Төслийн менежер Г.Гантулга, Хятадын багийн ахлагч Чанг Хайшан, Төслийн зохицуулагч О.Баярсайхан болон ӨӨХА-ны шинжээч, мэргэжилтэн нар гүйцэтгэсэн ажлын талаар илтгэл тавьж хэлэцүүлсэн байна.</p> <p>-2015 оны 12 дугаар сарын 08-нд 6 сар тутмын 2 дахь удаагийн уулзалтыг зохион байгуулсан ба ХХААЯ-ны ТНБД Н.Ариунболд, НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь дэд суурин төлөөлөгч Кевин Галлахар, ӨӨХА-ны шинжээч, мэргэжилтэн нар, Монгол талын хамтрагч төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцов. Төслийн менежер Г.Гантулга 2015 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцүүлж, 2016 оны төлөвлөгөөний төсөлд санал авсан.</p>	
5	Танилцах аялал I	Үйл ажиллагаа эхэлснээс 6-12 сарын дараа	ХХААЯ, НҮБ-ын ХХААБ БНХАУ-ын ЗГ	<p>-ХХААЯ-ны ТНБДарга Н.Ариунболд тэргүүтэй яам, НҮБ-ын ХХААБ болон төсөлтэй хамтран ажилладаг байгууллагуудын төлөөлөл бүхий нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй баг БНХАУ-д хийх танилцах аялал /Бээжин, Шанхай, Хөх хот, Хайларт/-д хамрагдсан. Аялалын хүрээнд 9 сарын 21-ны өдөр ХХААЯ-ны ТНБДарга Н.Ариунболд БНХАУ-ын ХААЯ-ны дэд сайд (ерөнхий агрономич) Сун Зонгхуа-тай Бээжин хотноо уулзаж хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа болон ӨӨХА-ны төслийн хэрэгжилтийн талаар тодорхой саналуудыг солилцсон.</p> <p>-Бээжин дэх Хөдөө аж ахуйн орчин үеийн судалгааны төв, Шанхайн Хөдөө аж ахуйн удирдах зөвлөл (загасны аж ахуй чиглэлээр), Шанхай дахь Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо судалгааны төв, Хөх хот дахь Хүнсний ногоо тариалангийн хоршоолол, Малын тэжээл үйлдвэрлэгч “Да Вэй Хонг” групп, Хөх хот дахь малын үржлийн төв, Хайлаарын Хөлөн нуурын загасны аж ахуй, Хөлөнбөөрийн малын тэжээл хадгалах байгууламж зэрэг Хятадын хөдөө аж ахуйн холбогдох байгууллагууд, удирдах ажилтан болон үйлдвэрлэгч нартай газар дээр нь уулзаж туршлага судлах, мэдээлэл солилцох, үзэл бодлоо хуваалцах, хамтын ажиллагаагаа тогтоох зэрэг ажлуудыг</p>	100.0

				<p>чиглэл бүртээ хийсэн.</p> <p>-Монголын баг Хятадын хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн гол тулгуур нь</p> <p>1. Тодорхой бодлого чиглэлтэй бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэх механизм сайтай. 2. Салбарын нэгдсэн төлөвлөгөө болон хөгжлийн тодорхой стратегитай. 3. Хөдөө аж ахуйн хөгжилд зориулж их хэмжээний хөрөнгө оруулалт хийгддэг. 4. Хөдөө аж ахуйн дэд салбаруудыг бүсчлэн хөгжүүлсэн. 5. Газар ашиглах зөв төлөвлөгөө боловсруулсан. 6. Санхүүгийн нөөц бололцоог зохистой ашигладаг гэсэн 6 үндсэн бүрэлдэхүүн болно гэж дүгнэлээ.</p>	
6	Дунд шатны гурван талт уулзалт	Үйл ажиллагаа эхэлснээс 12-14 сарын дараа	Төслийн нэгж ХХААЯ, НҮБ-ын ХХААБ БНХАУ-ын ЗГ	ХХААЯ-нд 2015 оны 09 дүгээр сарын 18-нд Италийн Ром дахь ӨӨХА-ны хөтөлбөрийн зохицуулагч Лиү Зонгвэй болон НҮБ-ын ХХААБ, ХХААЯ, төслийн хамтран хэрэгжүүлэгч нарын бүрэлдэхүүнтэй 3 талын хамтарсан хурал, хэлэлцүүлэг зохион байгуулсан.	100.0
7	Танилцах аялал 2	Үйл ажиллагаа эхэлснээс 12-20 сарын дараа	ХХААЯ, НҮБ-ын ХХААБ БНХАУ-ын ЗГ	БНХАУ-ын ХААЯ-ны Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсээс 2016 оны 9 дүгээр сарын 21-30-ны хооронд БНХАУ-д танилцах аялал зохион байгуулсан. Танилцах аялалд Монголын талаас 8 хүн оролцсон.	100
8	Төгсгөлийн шатны гурван талт уулзалт	Үйл ажиллагаа эхэлснээс 20-22 сарын дараа	Төслийн нэгж ХХААЯ, НҮБ-ын ХХААБ БНХАУ-ын ЗГ	<p>-ӨӨХА II төслийн хаалтын үйл ажиллагааг 2016 оны 10 сарын 17 өдөр “Туушин” зочид буудлын хурлын танхимд зохион байгуулсан байна.</p> <p>-Хаалтын үйл ажиллагаанд хамтарч ажилласан байгууллагууд, БНХАУ-ын мэргэжилтнүүд, НҮБ-н ХХААБ-н дэд суурин төлөөлөгч болон ХХААХҮЯ-ны албан хаагчид оролцсон байна. Хаалтын хурлыг төслийн үндэсний зохицуулагч, ХХААХҮЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Биндэръяа, НҮБ-ын ХХААБ-ын дэд суурин төлөөлөгч ноён Кевин Галлагхер нар хэлж хаалтын үйл ажиллагааг эхэлсэн байна. Б.Биндэръяа ӨӨХА II төслийн хүрээнд 2014-2016 онд хийсэн ажил, төслийн үр дүнг тайлагнасан байна.</p> <p>-Хаалтын үйл ажиллагааны үеэр БНХАУ-н мэргэжилтнүүд болох Ву Дуо, Лүй Чангхай, Канг Лианхэ нар ХХААХҮЯ-ны жуух бичгээр, Хятадын төслийн багийн ахлагч Чанг Хайшан НҮБ-н хүндэт медалиар тус тус шагнагдсан. Хурлыг хааж Б.Биндэръяа үг хэлснээр хаалтын үйл ажиллагаа албан ёсоор өндөрлөсөн байна.</p>	100
<b>ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ</b>					<b>100.0</b>

### ҮР ДҮНГИЙН БИЕЛЭЛТ

Аж ахуйн шинэ технологи, мэдлэгийн шууд болон шууд бус өгөөж/үр шим, хүнсний аюулгүй байдал сайжирна.

Хүлээгдэж буй үр дүн	Хэрэгжилт	Үнэлгээ, хувь
<p>Үр дүн 1. Өмнөд өмнөдийн хамтын ажиллагааны техник туслалцааны хүрээнд хэрэгжүүлэгч нэгжийн технологи сайжирсан байх</p>	<p>-Төсөлд хамтран ажиллаж буй байгууллага, аж ахуйн нэгжид дараах тоног төхөөрөмж, техник, бараа материалыг нийлүүлсэн байна Үүнд:          -АДОБА-ын захиргаа, БМ-ийн холбоо, “Манлай уургач” ХХК-иудад арвайн үр, Ерхөг, согооврын үр, царгасны үр, Эрдэнэшиш, судан өвс зэргийг худалдан авахад 110.4 сая төгрөгийг 2015 онд, 2016 онд АДОБА-ын захиргаа, БМ-ийн холбоонд царгасны, арвайн, Эрдэнэшишийн, судан өвсний үр, GPS худалдан авахад 20.5 сая төгрөгийн худалдан авалтыг 2016 онд хийсэн байна.          -МУСҮ-ний төвийн хэрэгцээнд зориулж трактор, өвс хадагч, хөврөл шилжүүлэн суулгах иж бүрэн тоног төхөөрөмжийг 45.8 сая төгрөгөөр худалдан авч 2015-2016 онд нийлүүлсэн байна.          -“Манлай уургач” ХХК-д 12.3 сая төгрөгийн үнэ бүхий Ази культватор, ротор культватор, хүнсний ногооны үрсэлгээ суулгагч болон нарлаг хүлэмжийн тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлсэн байна.          -“Сэнжит оюу” ХХК-д 36.9 сая төгрөгийн үнэ бүхий дуслын усалгааны систем, трактор, нарлаг хүлэмжийн тоног төхөөрөмж зэргийг 2015-2016 онд нийлүүлсэн байна.          -“Хилэм ост” ХХК-д 8.8 сая төгрөгийн үнэ бүхий загас үржүүлгийн цөөрмийн усан сан байгуулахад шаардагдах материал нийлүүлсэн байна.          -“Түмэн сүйх” ХХК-д 36.4 сая төгрөгийн үнэ бүхий өргөст хэмхийн үр, коконутын хөрс, ургамал арчлагч өргөгч цамхаг, трактор, роторт культватор, үрслэг шилжүүлэн суулгагч, усалгааны систем зэргийг 2015-2016 онд нийлүүлсэн байна.          -Мөнтүүнчлэн БМ-ийн холбоонд 29.7 сая төгрөгийн үнэ бүхий тармуур, хадуур зэргийг худалдана авч нийлүүлсэн байна.          -“TSAT” ХХК-д 35.9 сая төгрөгийн тахианы тэжээлийн цехийг 2016 оны 08 дугаар сард нийлүүлэх ажлыг төслөөс зохион байгуулсан.</p> <p>Дүгнэлт:</p>	100.0
<p>Үр дүн 2. Өмнөд өмнөдийн хамтын ажиллагааны чадавхи хөгжүүлэх хүрээнд аж ахуй эрхлэх дадалтай холбоотой чадавх сайжирсан байх</p>	<p>-Төслийн хүрээнд БНХАУ-аас урт хугацааны 9 зөвлөх, техникийн ажилтан Монгол ирж төслийг хамтран хэрэгжүүлэгч 67 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудад мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан байна.</p> <p>-Төслийн хүрээнд “Үхрийн зохиомол хээлтүүлгийн техник арга ажиллагаа”, “Тэжээлийн таримал тариалах технологи”, “Хатан зөгий үржүүлэх технологи”, “Наран хүлэмж байгуулах”, “Хүлэмжинд хүнсний</p>	100.0

	<p>ногоо ургуулах агротехник ургамал хамгаалал”, “Малын тэжээлийн ургамал тариалах”, “Хонинд хөвврөл шилжүүлэн суулгах”, “Бэлчээрийн менежментийг сайжруулах арга зам” сэдэвт 8 удаагийн сургалт зохион байгуулж 396 хүнийг хамруулсан ба сургалтын дараах санал асуулгаар сургалтын үр дүн 94-97 хувьтай дүгнэгдсэн байна.</p> <p>-Мөн түүнчлэн 2015-2016 онд төслийн хүрээнд 8 удаагийн сургалт зохион байгуулах, 3 удаагийн танилцах аялалд 186.2 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>-Хамтран ажиллагч аж ахуй эрхлэгчдэд дадлага олгох чиглэлээр “Загасны өвчинтэй тэмцэх арга ажиллагаа”, “Өндөглөгч тахиа үржүүлэх менежмент”, “Зөгийн аж ахуй эрхлэх технологи” гарын авлага боловсруулан холбогдох аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн байна.</p> <p>-Хүлэмжинд зарим хүнсний ногоог хөрсгүй орчинд ургуулах технологи нэвтрүүлэх /лооль/ туршилт хийх ажлыг зохион байгуулсан байна.</p>	
<p>Үр дүн 3. МАА, газар тариалангийн үйлдвэрлэл сайжирсан байх</p>	<p>-Төсөлд хамтран ажилласан аж ахуйн нэгжүүдийн МАА болон газар тариалангийн үйлдвэрлэлд дараах үр дүн гарсан байна. Малын удмын сангийн үндэсний төв (МУСҮТ), ӨӨХАИ төслийн мэргэжилтэнтэй хамтран малын зохиомол хээлтүүлэг, үр гүн хөлдөөх болон үр хөврөл шилжүүлэн суулгах зэрэг мал үржүүлгийн биотех-нологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:</p> <p>- МУСҮТ-ийн болон ӨӨХА-ны мэргэжилтэн нар 2 жилийн хугацаанд нийт 258 үнээнд ороо жигдрүүлэлт хийж, 252 саалийн үнээнд зохиомол хээлтүүлэг хийснээс 248 үнээ хээл авч, үр тогтолт 98.4 хувьд хүрсэн нь өнөөгийн зохиомол хээлтүүлэг хийж байгаа түвшнээс даруй 6-7 хувь илүү байна.</p> <p>2.Аймаг Дундын Отрын Бүс Ашиглалтын захиргаа (АДОБАЗ), “Монголын бэлчээрийн менежментийн холбоо” (МБМХ), “Манлай уургач” ХХК зэрэг байгуулагуудад тэжээлийн таримлын шинэ сорт сорих, нэг ба олон наст таримал тариалах, эрдэнэшишийн дарш бэлтгэх зэрэг технологи нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:</p> <p>-АДОБА-ын захиргаа, БМ-ийн холбоо, МУСҮ-ний төв болон “Манлай уургач”, “Түмэн сүйх”, “Сэнжит Оюу”, “Түмэн сүйх”, “TSAT” ХХК-иудад царгасны, арвайн, Эрдэнэшишийн, судан өвсний үр, Ази культватор, ротор культватор, хүнсний ногооны үрсэлгээ суулгагч болон нарлаг хүлэмжийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн, мөн даршны болон хүнсний эрдэнэшишийн 11 сортыг туршиж үзсэн, зарим сортууд ирээдүй болохыг урьдчилан тогтоосон, газар тариалангийн үйлдвэрлэлд бодитой дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>- ӨӨХА-ны төслийн зөвлөмж, (тарилтын өмнөх хөрс боловсруулалт, тариалах хугацаа, хог ургамалтай тэмцэх арга хэмжээ, усалгаа) тариалах технологийг мөрдөж ажилласан Бумбат таван богд” хоршоо нь Сэлэнгэ аймгийн Жавхлант сум дахь талбайдаа даршны зориулалтаар эрдэнэшишийн “Же Дан” сортыг 13 га талбайд 2015 онд, 2016 онд “Нан Бей И Хао”</p>	<p>90.0</p>

	сортыг 13 га талбайд тус тус тариалж, 2015 онд га - аас 2.3 тонн ногоон масс, 2016 онд 100 тонн буюу га-аас 7.7 тонн ногоон масс хурааж, ургацын хэмжээг 3.3 дахин нэмэгдүүлж, хураан авсан ногоон массаараа дарш бэлтгэж эрчимжсэн саалийн үнээний фермд нийлүүлж, хоршоо ашиг орлогоо нэмэгдүүлжээ.	
<b>ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ</b>		<b>96.6</b>

### ДҮГНЭЛТ

1. Төслийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 8 ажил тусгагдсанаас 2016 оны жилийн эцсийн байдлаар биелэлт 100.0 хувь, үр дүнгийн биелэлт 96.6 хувьтай дүгнэгдэж байна. 2016 онд үйл ажиллагааны, худалдан авах ажиллагааны болон сургалтын төлөвлөгөө тус тус гарган хэрэгжилтийг хангасан байна.
2. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтээр тооцсон ба дунджаар 82.2 хувь, сургалтын төлөвлөгөөний биелэлт 100.0 хувь, худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 90 хувьтай буюу 2016 оны ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ дунджаар 90.7 хувьтай байна.
3. Төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн “Хүнсний ногоог байгаль орчинд ээлтэй технологиор тарих ургуулах” ажлыг практикт нэвтрүүлэх ажлын хүрээнд 2 га газар төлөвлөсөн боловч, цахилгаан холбох зардал өндөр байсан тул энэ ажил хийгдэж чадаагүй байна.
4. Сургалтын төлөвлөгөөнд 6 сургалт, 2 семинар, 2 танилцах аялал, 1 зөвлөлдөх уулзалт, нийт 11 төрлийн үйл ажиллагаа тусгагдсанаас бүх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн буюу төлөвлөгөө 100 хувь биелсэн байна.
5. Төслийн ажлыг “Баруун болон зүүн бүсийн аймгийн 300 га талбайд тэжээл тариалах технологи нэвтрүүлэх” гэсэн заалтын хүрээнд зорилтот бүсийн аймгууд ороогүй, харин төвийн бүсийн Төв, Сэлэнгэ аймгууд сонгогдсон байна.

### ЕС. ЗӨВЛӨМЖ

1. Энэхүү төслөөс 2016 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр тус яаманд хүлээлгэн өгсөн тайлан нь хэт товч, тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл ороогүй байгаа тул төслийн ажлын тайланг шинээр бүрдүүлэн авах шаардлагатай бөгөөд тайланг албан ёсоор хүлээн авч, хамтран ажилласан байгууллага, төсөл хэрэгжүүлсэн аймгуудад хүргүүлэх ажлыг 2017 оны 04 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулахыг,